210401	Бичиг хэрэг	9,583,100.00	9,372,100.00
210402	Тээвэр, шатахуун	81,546,200.00	81,201,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,640,500.00	6,683,800.00
210404	Ном, хэвлэл	2,038,900.00	1,828,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,422,400.00	11,344,090.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,721,200.00	36,559,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>324,885,000.00</b>	<b>297,809,194.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	72,161,500.00	71,901,524.00
210502	Хоол, хүнс	238,798,700.00	212,004,670.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,924,800.00	13,903,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>79,055,100.00</b>	<b>77,556,330.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	49,733,100.00	48,549,530.00
210602	Тавилга	2,000,000.00	2,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,600,000.00	1,600,000.00
210604	Урсгал засвар	25,722,000.00	25,406,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>9,729,900.00</b>	<b>8,310,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	9,729,900.00	8,310,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,334,000.00</b>	<b>8,825,143.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,189,400.00	2,440,042.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,232,400.00	2,088,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	493,000.00	293,955.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	362,800.00	275,746.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	234,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,514,200.00	3,419,000.00

210807	Газрын төлбөр	308,200.00	308,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>59,444,300.00</b>	<b>56,449,243.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,031,700.00	35,291,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,412,600.00	21,157,293.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>76,066,000.00</b>	<b>72,171,537.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>76,066,000.00</b>	<b>72,171,537.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	70,057,400.00	66,265,107.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,008,600.00	5,906,430.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>354,971,400.00</b>	<b>244,989,164.44</b>
223001	Бусад хөрөнгө	354,971,400.00	244,989,164.44
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>128,000,000.00</b>	<b>129,840,000.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	128,000,000.00	129,840,000.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,292,356,300.00</b>	<b>5,029,158,523.00</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,688,143,500.00</b>	<b>3,657,886,022.00</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3,553,206,900.00	3,522,949,340.00
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	134,936,600.00	134,936,682.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,250,928,600.00</b>	<b>1,219,792,141.00</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,250,928,600.00	1,219,792,141.00
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>52,999,400.00</b>	<b>20,728,560.00</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	52,999,400.00	20,728,560.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>300,284,800.00</b>	<b>130,751,800.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,250,000.00	130,751,800.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	170,034,800.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	180,229,063.74
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	129,684,722.79

## 2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>261,146,011.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>261,146,011.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>194,568,404.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>80,798,823.88</b>
210102	Нэмэгдэл	80,798,823.88
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>8,621,476.12</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,621,476.12
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,324,217.00</b>
210401	Бичиг хэрэг	1,801,707.00
210402	Тээвэр, шатахуун	7,300,010.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,595,000.00
210404	Ном, хэвлэл	930,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,397,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>76,115,880.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	66,341,380.00
210502	Хоол, хүнс	9,774,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,290,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,390,000.00
210604	Урсгал засвар	900,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>500,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,531,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,705,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	736,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,387,007.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,168,007.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,219,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>66,577,607.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>66,020,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	66,020,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>557,607.00</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	557,607.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>261,146,011.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>261,146,011.00</b>
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,507,607.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,405,404.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	239,233,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тэс сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэс сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Шалгагдагч этгээд, түүний орчин ба дотоод хяналт

Тэс сумын Засаг дарга нь “Байгалийн баялаг, орон нутгийн нөөц боломжид түшиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтэц, аялал жуулчлал хөгжсөн, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан бүхий, хүний хөгжлийг дээдэлсэн, чинээлэг иргэдтэй сум болно” гэсэн гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлэх
- Байгаль хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх
- Орон нутагт дэд бүтэц, бизнесийн орчныг сайжруулах
- Байгалийн баялаг, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх
- Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган чанар хүртээмжийг дээшлүүлэх
- Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Шалгагдагч этгээдийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Тэс сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлаар тооцож 33.4 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын 80 хувиар тооцож 26.7 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Тэс сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 114.2 сая төгрөгөөр буюу 0.78 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/сая.төгрөг/
Мөнгөн хөрөнгө	276.8	225.5	-51.3
Авлага	253.3	354.6	101.3
Урьдчилгаа	0.0	0.0	
Бараа материал	364.3	446.6	82.3
Үндсэн хөрөнгө	13,725.2	13,478.7	-246.5
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>14,619.6</b>	<b>14,505.4</b>	<b>-114.2</b>
Нийт өр төлбөр	18.9	17.6	-1.3
Засгийн газрын хувь оролцоо	14,600.7	14,478.8	-121.9
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>14,619.6</b>	<b>14,505.4</b>	<b>-114.2</b>

Эх сурвалж: Тэс сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 225.5 сая төгрөг болж 51.3 сая төгрөгөөр буурсан нь орон нутгийн ерөнхий орлого, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурснаас шалтгаалжээ.

### 3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 354.6 сая төгрөг болж 101.3 сая төгрөгөөр өссөн нь Сум хөгжүүлэх сан, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ.

#### Харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:

- Санхүүгийн тайланд 130.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг тусгаагүй байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 446.6 сая төгрөг болж 82.3 сая төгрөгөөр өссөн нь Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Эрүүл мэндийн төвийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 13,478.7 сая төгрөг болж 246.5 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

### 3.5.5 Нийт өр төлбөр

Өр төлбөр дансны үлдэгдэл 17.6 сая төгрөг болж, 1.3 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

#### Харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:

- Тэс сумын Засаг даргын тамгын газар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь хэсэгт "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.4.3 дахь заалтад "бүх өр төлбөр заавал бүртгэнэ" гэж заасныг зөрчин ажилтнуудаас суутгасан тооцсон үйлдвэрчний эвлэлийн татвар 1,986.4 мянган төгрөгийг өглөгөөр тусгаагүй байна.
- Тэс сумын Засаг даргын тамгын газар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь хэсэгт "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.4.3 дахь заалтад "бүх өр төлбөр заавал бүртгэнэ" гэж заасныг зөрчин нийгмийн даатгалын өглөг 171.5 мянга, хувь хүний орлогын албан татварын өглөг 382.9 мянга, нийт 554.4 мянган төгрөгийн өглөгийг дутуу тусгасан байна.
- Тэс сумын Соёлын төв Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчин санхүүгийн тайланд нийгмийн даатгалын

*шимтгэлийн 303.5 мянга, үйлдвэрчний эвлэлийн татварын 310.2 мянга, нийт 613.9 мянган төгрөгийн өглөгийг тусгаагүй байна.*

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 14,487.8 сая төгрөг болж 121.9 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна. Энэ нь тайлант үеийн үр дүн алдагдалтай гарсантай холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,892.9 сая төгрөгөөр буюу 21.7 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 643.9 сая төгрөгөөр буюу 9.6 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.5.5 Орлогын данс**

Тайлант онд татварын орлого 102.1 сая, татварын бус орлого 2,265.9 сая, тусламж санхүүжилтийн орлого 4,471.2 сая, нийт 6,839.2 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

### **3.5.6 Зардлын данс**

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 2.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

#### **Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:**

*- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас цагдаагийн хэсгийн интернэтийн төлбөрт 185.0 мянга, бичиг хэргийн зардалд 32.5 мянга, камерийн кабелийн үнэд 185.0 мянга, бензиний зардалд 1865.0 мянга, нийт 2182.5 мянган төгрөгийн зардлыг тушаал шийдвэргүйгээр зориулалт бусаар зарцуулсан алдаа зөрчилд албан шаардлага өглөө.*

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тэс сумын 2021 оны төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2/05 дугаар тогтоолоор 4,167.2 сая төгрөгөөр баталж 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 4/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 215.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 4,382.3 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,292.3 сая төгрөгийн төсөв баталснаас 3,688.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,250.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 52.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 130.2 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,657.9 сая, орон нутгийн төсвөөс 1,219.8 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 20.7 сая, төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 130.7 сая, нийт 5,029.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл

ажиллагаанд 4,611.7 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 82.9 сая, орон нутгийн төсөвт 40.6 сая, нийт 123.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,986.5 сая төгрөг буюу 94.2 хувьтай байгаа нь зардлыг 123.5 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Тэс сумын ИТХ-ын 2021 оны 08 дүгээр сарын 12-ны өдрийн сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай 4/01 дүгээр тогтоолд зааснаар Тэс сумын Засаг дарга тайлант онд 133.6 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 102.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 76 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 11.4 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 239.2 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 10.5 сая нийт 261.1 төгрөгийн орлогыг бүрдүүлж 261.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Тэс

сумын Засаг даргын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 156 мэдээллээс хугацаандаа оруулсан 135, хугацаа хоцроож 16 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 10 байгууллага, нэгж байршуулах мэдээллээс 1,405 мэдээллийг хугацаанд нь 96 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

**Харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:**

- Тэс сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,879,959.1 мянган төгрөгийн 14 гүйлгээ, Таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 32,639.3 мянган төгрөгийн 2 гүйлгээ, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 268,632.4 мянган төгрөгийн 14 гүйлгээг мэдээлээгүй өмнөх оны алдааг давтан гаргасан байна.
- Тэс сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 150,271.2 мянган төгрөгийн 8 гүйлгээ, Таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 11,475.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй өмнөх оны алдааг давтан гаргасан байна.
- Тэс сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 205,593.2 мянган төгрөгийн 10 гүйлгээ, Таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 5,070.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй өмнөх оны алдааг давтан гаргасан байна.
- Тэс сумын Эрүүл мэндийн төв цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 245,250.0 мянган төгрөгийн 6 гүйлгээ, Таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 16,721.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, Таван сая төгрөгөөс дээш нийт зарлагын гүйлгээний мөнгөн дүн бүхий зарлагын 36,825.4 мянган төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны алдааг давтан гаргасан байна.
- Тэс сумын Таван улиас хүний их эмчийн салбар цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 91,422.2 мянган төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны алдааг давтан гаргасан байна.
- Тэс сумын Хар үзүүр хүний их эмчийн салбар цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 79,430.2 мянган төгрөгийн 7 гүйлгээ, Таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 6,750.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, Таван сая төгрөгөөс дээш нийт зарлагын гүйлгээний мөнгөн дүн бүхий зарлагын 6,750.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны алдааг давтан гаргасан байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 115.3 сая төгрөгийн 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

д/д	Зөвлөмжийн утга	Хэрэгжилт	Хувь
1	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.	Тэс сумын Засаг даргын 2021.04.28-ны 104 тоот албан бичгээр ирүүлсэн байна.	100%

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар сумдын Засаг даргын тамгын газрын, багийн бүтэц орон тоог батлахдаа гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна. Дараагийн аудитаар энэ асуудлыг анхаарч шалгах нь зүйтэй гэж үзлээ.

### 3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Тэс сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 10 байгууллагын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 3,042.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3.2 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 3,038.9 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага өглөө.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ИТХ	1	2.2					1	2.2		
2	ЗДТГ	2	2.5	2	2.5						
3	ЕБ-ын 1 дүгээр сургууль	1	2,181.2					1	2,181.2		
	ЕБ-ын 2 дугаар сургууль	1	161.7					1	161.7		
	ЕБ-ын 3 дугаар сургууль	1	210.7					1	210.7		
	Хүүхдийн цэцэрлэг	1	0.138	1	0.138						
	Соёлын төв	1	0.6	1	0.6						
4	ЭМТ	1	298.8					1	298.8		
	Таван улиас Хүний их эмчийн салбар	1	91.4					1	91.4		
	Хар үзүүрийн Хүний их эмчийн салбар	1	92.9					1	92.9		
	<b>Дүн</b>	<b>11</b>	<b>3,042.1</b>	<b>4</b>	<b>3.2</b>			<b>7</b>	<b>3038.9</b>		

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тэс сумын Засаг дарга	0	0.0								
<b>НИЙТ</b>		<b>0</b>	<b>0.0</b>								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР /С.БАТСАЙХАН/

2022 оны 03 сарын 21-ний өдөр